



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар Б/133

Улаанбаатар хот

┌ Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг ┐
шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тамгын газрын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-ны гишүүн Ж.Дуламсүрэн, Ц.Азжаргал нар нь ажлаас чөлөөлөгдсөн тул байгууллагын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар олонхын дэмжлэг авсан албан хаагчдыг нөхөн томилж Дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсүгэй.

2. Ёс зүйн дэд хорооны шинэчилсэн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, урамшууллын хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нөхөн сонгогдсон гишүүдийг удирдлага, арга зүйгээр ханган, бүрэн эрхийн хугацааг орон гарсан гишүүдийн бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар тооцон ажиллуулахыг Ёс зүйн дэд хороо (С.Туулмаа)-нд үүрэг болгосугай.

4. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллыг хавсралтад заасны дагуу тооцож Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргахыг Санхүүгийн тасгийн дарга бөгөөд Ахлах нягтлан бодогч (Д.Батболд)-д зөвшөөрсүгэй.


5. Энэ тушаал гарсантай холбоотой дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/132 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

1825030496

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2025 оны 04.....
дугаар сарын 09...-ны өдрийн 5/33 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

Ёс зүйн зөвлөлийн дарга:	С.Туулмаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	А.Бямба	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (нөхөн сонгогдсон)
	Д.Мөнгөндалай	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (нөхөн сонгогдсон)
	Г.Өлзийхутаг	Аж ахуйн тасгийн Хангамж хариуцсан ажилтан
	Ө.Чамин-Эрдэнэ	Дүүргийн 5 дугаар хорооны Зохион байгуулагч
	Ш.Ганчимэг	Дүүргийн 38 дугаар хорооны Нийгмийн ажилтан
Нарийн бичгийн дарга:	Г.Одбилэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Бодлогын баримт бичгийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Ахлах мэргэжилтэн

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2025 оны ...04...
дугаар сарын 09...-ны өдрийн 5/32 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ГИШҮҮДЭД ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Урамшууллын хэмжээ	Хугацаа	Тайлбар
1	Дэд хорооны дарга, гишүүд	792,000 хүртэл	Улиралд нэг удаа	Хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцно.
2	Нарийн бичгийн дарга	396,000	Сар бүр	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээгээр тооцно.

Жич: Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилсэн тохиолдолд Дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн даргын урамшууллыг шинэчлэн тогтоосон хэмжээгээр тооцож үргэлжлүүлэн олгоно.

---ooOoo---